



## ОРЧИН ҮЕИЙН ДИЗАЙНЫ УРЛАГИЙН МӨН ЧАНАР

Ч.Мөнхбаяр

МУБИС-ийн УБТС-ийн Зураг зүй, Дизайны тэнхимийн багш

**Abstract:** Nowadays the concept of design is the most active phenomenon and is used in almost all areas of the society. Surprisingly, the word “design” is used with any words. However, we can say that many people do not know what this wonderful word means. Design contains many activities and concepts of many fields of the humanities and design theories are always changed concerning the time, social changes and development as well. There are many definitions of “design”, but the concept of “design” is developed from the material world to the spiritual product of a man, so the old definitions cannot completely define and express the nature of the “Design”. Today the development of mental abilities is highly appreciated in the world. Freethinking is more valued in child education. Therefore, the present trend of primary education around the world is directed to develop freethinking of a child, and creative thinking of secondary and upper-secondary school children. The main tool to develop freethinking is a fine art while the DESIGN is to develop creative thinking. Therefore, we must pay attention to the development of of Design Education in Mongolia.

**Түлхүүр үг:** Дизайн, дизайны түүх, дизайны урлаг, хөгжил, чиг хандлага, дизайны боловсрол

XIX, XX зууны зааг дээр урлаг, үйлдвэрлэлийн хосолмол шинжийг агуулан үүсэж, XX зууны уран сайхны зураг төсөл, зохион бүтээлтийн хамгийн нөлөөтэй хэлбэр болж байсан дизайн хэмээх ойлголт орчин үед нийгмийн салбар бүрт хэрэглэгддэг ухагдахуун болж төлөвшжээ. Дизайн нь

цаг үетэйгээ зэрэгцэхээс гадна түрүүлж явдаг онцлогтой бөгөөд дизайны эрэл хайгуулын дүнд бид ирээдүйг урьдчилан харах боломжтой. “Нийгэмд юу ч болж байсан бүгд дизайн тусгалаа олж дараагийн чиг хандлагыг тогтооно”. (Рунге, 2006). XXI зуунд урлаг, соёл, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг даган эрчимтэй хөгжиж, хүний оюун ухаанаас төрөх бүхий л ойлголтод тусгалаа олсон нийгэм, соёлын өвөрмөц үзэгдэл юм. Дэлхий нийтийн хөгжилтэй харьцуулахад Монгол оронд энэхүү нэр томъёог хэрэглээд харьцангуй бага хугацаа өнгөрч буй боловч нэн эрчимтэй хөгжиж байна. Урьд нь ЗХУ-аас зээлсэн “уран сайхны зураг төслийн ажил”, “уран сайхны зохион бүтээлт”, техникийн гоо зүй” зэрэг нэр томъёог мэргэжлийн явцуу хүрээнд хэрэглэдэг байсан бол одоо дурын үгний ард “дизайн” гэдэг үг залгаад хэлэхэд хэн ч гайхахаа больжээ. Гэвч энэхүү гайхамшигт “дизайн” гэдэг үгийг тодорхой тайлбарлаж чадах хүн тун цөөн гэж хэлж болно.

Дизайны онолын судалгаа нь дэлхий нийтээр нэн хэрэгцээтэй судалгааны талбарт тооцогдож байгаа бөгөөд 80-аад оны “Дизайны ерөнхий онол” болон “Аксиом дизайн”, 90-ээд оны “хосолмол дизайн”, 2000 оны “Сэлбэгдэх дизайн” болон “С-К онол” гэх мэт үе үеийн дизайны онолын чиг хандлагыг судлан шинэчлэх шаардлагатай болж байна. (Массон, 2013)

Судлаачид “Дизайн” гэдэг үгийн уг гарлыг хэд хэдэн хувилбараар тайлбарладагаас хамгийн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн нь “тодорхойлох, илэрхийлэх гэсэн утга бүхий “Designare” хэмээх латин үгнээс гаралтай” гэдэг дүгнэлт

юм. Сэргэн мандалтын үед “disegno” хэмээх итали үг зураг төсөл, хар зураг, санааг илэрхийлдэг байв. Хожим нь XVI зуунд санаа, зураг төсөл, хээ угалз, зохион бүтээлт гэх мэт өргөн утгыг агуулсан “design” гэх нэр томъёо Англид бий болж өнөөг хүрчээ. Үүнээс гадна “Design” гэдэг үгийн гарлыг мөн “de+signum” хэмээх латин үгнээс гаралтай хэмээн тайлбарлаж, Оксфордын толь бичиг утгыг нь 1548 онд “зорилго, чиглэл”, 1593 онд “хийх зүйлийн оюун ухаан дахь төлөвлөгөө”, 1638 онд “бүтээх төлөвлөгөө”, 1697 онд “ямар нэгэн зүйлийг зохион бүтээх урьдчилсан хар зураг” гэх мэтээр жил жилээр тайлбарлаж иржээ. (Михайлов, 1999).

Герман хэлтэн орнуудад 1945 он хүртэл үйлдвэрлэлтэй холбоогүй байсан бүтээгдэхүүний чимэглэл – Gestaltung гэдэг ойлголтыг мөн дизайн гэж ойлгодог байсан бол 1945 оноос хойш “үйлдвэрлэлийн загварчлал”- Formgestaltung гэдэг ойлголт гарч ирсэн байна. (Рунге, 2006)

Дизайны түүх хүний хүрээлэн буй биет орчин, техник технологийн хөгжилтэй нягт холбоотой. Дизайны биет объектыг ерөнхийд нь хоёр ангилж болох юм.

Нэгдүгээрт, гар урлал, хавсрага урлагийн хүрээнд хэдэн зууны турш хөгжөөд хожим дизайны төрөл болсон үүрэг зориулалт нь бараг өөрчлөгдөөгүй сав суулга, тавилга, эдлэл гэх мэт эд зүйлс орно.

Хоёрдугаарт, шинэ техник технологи, зохион бүтээлтэй холбоотой автомашин, цахилгаан хэрэгсэл гэх мэт хавсрага урлагийн төрөлд хамааруулах боломжгүй дизайны бүтээлүүд орно. Эдгээрийн түүх харьцангуй богино бөгөөд хамгийн эртний машин ч хамгийн сүүлийн морин тэрэгнээс ялгаатай гэдэг. Энэ төрлийн онцлог шинж нь механизм, техникт суурилсан шинэ үүрэг зориулалтад оршино.

Хавсрага урлагийн бүтээл болсон дахин давтагдашгүй шинж чанартай эдлэл, дизайнерын шийдлийг агуулсан бүтээгдэхүүн ерөнхийдөө ялгагддаг хэдий ч зарим тохиолдолд ялгахад хэцүү байдаг. Эртний уламжлалт гаралтай бүтээгдэхүүний орчин үеийн дизайн шийдэлд уг эдлэлийн

гарваль шинж нь агуулагдсан байдаг нь тухайн эдлэлийн анх бий болсон хэв маягтай холбоотой бөгөөд хөгжлийнх нь аль ч үе шатыг дизайны өмнөх түүхэнд хамааруулан судлах боломжтой юм. Нэгдүгээр ангилалд мөн уран барилгатай холбоотой дизайны төрлүүдийг оруулж болно. Жишээ нь, Уильям Моррис алдарт “Улаан байшин”-гаа бүтээхдээ уран барилгач байсан уу, дизайнер байсан уу гэдгийг хэлэхэд хэцүү бөгөөд дизайн, хавсрага урлагийн зааг бүдгэрсэн байна. (Паранюкшин, 2006)

XIX зууны эхэн үеийн дизайны түүхэнд соёл урлаг, техникийн хөгжлийн зөрчлөөс үүдэлтэй эсрэг, тэсрэг олон үзэл баримтлал, урсгал чиглэл дэлгэрч байсан. Жишээ нь XIX зууны сүүл үед дэлгэрсэн инженерийн хэв маяг, уран барилгын хэв маяг, уран сайхны “кич” зэрэг хэв маягийг дурьдаж болно. (Михайлов, 2002). “Кич” (гер.Kitsch) нь машинаар үйлдвэрлэсэн эдлэлийг зурж чимэглэдэг, гар урлал, дизайны шилжилтийн үеийн өвөрмөц үзэгдэл юм

Дизайны үүсэл хөгжлийн түүхийг цаг үеэс хамааран судлаачид олон янзаар тооцдог. Дизайны анхдагчаар 1843 онд “механик үйлдвэрлэлд хавсарсан гоёмсог урлаг, гоо сайхныг” илэрхийлэх “үйлдвэрлэлийн урлаг” (“Art manufactures”) гэдэг нэр томъёог гаргасан Английн зураач Хенри Коулыг (1808-1882) тооцох нь бий. Тэрээр 1849-1852 онд төслийн ашиг болон худалдааны үнэ цэнд чиглэсэн “Дизайны сэтгүүл” (Journal of Design) гаргаж байжээ. Гэвч түүнээс өмнө 1832 онд Английн үйлдвэрлэгч, улс төрийн зүтгэлтэн Роберт Пиль Английн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэхжүүлэхийн тулд урлагийг ашиглахыг уриалж байсан байсан баримт бий.

Олонх судлаач дизайны эхлэлийг 1907 онд зураач, архитекторч, дизайнер Петер Беренсийн «АЕГ» («Allgemeine Elektrizität Gesellschaft») компанид ажиллах болсонтой холбож үздэг. Ингэсэн тохиолдолд У.Моррис, Ж.Рескин нартай холбогдох өмнөх жилүүд нь дизайны зөвхөн онолын бэлтгэл үе гэж тооцогдох юм. (Ковешникова, 2009)

Хэрэв дизайныг биет орчныг

шинэчлэх болон техникийн хөгжилтэй холбож үзвэл дизайны түүхийг 1919 онд Вальтер Гропиус Баухаузыг үүсгэсэн цаг үеээс эхлэсэн гэж үзэж болно. Харин дизайныг урлаг, техникийн уялдаа холбоонд авч үзвэл машин уран бүтээлчийн гарт урлагийн хэрэгсэл болж болно гэх үзлийг манлайлагчид болох Анри Ван де Вельде, Фрэнк Ллойд Райт нартай холбож үзэх боломжтой болно.

Мөн худалдааны хүндрэлтэй тулгараад байсан Америкийн үйлдвэрлэлд Рэймонд Лоуи, Уолтер Дорвин Тииг, Хенри Дрэйфус зэрэг зураач ажиллах болсон 1929 оны хямралын үеэс дизайн үүссэн гэж үзэх нь ч байдаг. (Рунге, 2006)

Гэвч орчин үеийн байр сууринаас авч үзвэл дизайны үүслийг аливаа цаг үед хамааруулан тооцох нь учир дутагдалтай юм. Жишээ нь, бараа бүтээгдэхүүний дизайнд үүрэг зориулалт, бүтэц, эдийн засгийн болон гоо зүйн чанаруудыг харгалзуулж үздэг. Гэтэл орчин үеийн үйлдвэрлэлийн дизайнеруудын гүйцэтгэж, олноор үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний загварыг гаргах ажлыг Ромын эзэнт гүрний томоохон гар үйлдвэрүүд болон дундад зууны үеийн тавилгын зураач нарт ч хамааруулж болно. Хүн төрөлхтөний эрт цагаас бүтээж ирсэн олон зүйлийг орчин үеийн дизайны шалгуураар авч үзэхэд төгс нийцэж байдаг нь нууц биш.

Монгол ахуйд хэрэглэж ирсэн олон эдлэл, жишээлбэл, монгол гэрийг авч үзэхэд хэн нэгний зохион бүтээж, олноор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн биш, олон зууны хугацаанд хөгжин боловсорч ирсэн нүүдлийн соёл иргэншлийн том өв тул дизайны бүтээл биш гэж хэлж болно. Гэтэл гэрийн бүтэц, зориулалт, хэрэглээний хувьд дизайны төгс шийдэлтэй байдаг. Энэ тал дээр судлаачдын санаа ихэд зөрөлддөг билээ.

Иймээс орчин үеийн судлаачид дизайны түүхийг хүн төрөлхтөний эртний соёл иргэншлийн түүхээс эхлэн биет (материаллаг) орчны хөгжлөөс эхлэн судлах хэрэгтэй гэж үзэн эртний Египет, Грек, Ром, Дундад зууны үе, сэргэн мандалт, шинэ үеийн хавсрага урлагийн түүхийг дизайны

түүхийн өмнөх үе хэмээн судлах болсон байна.

XX зууны эхэн үеийн судлаачид дизайныг тодорхойлоход харьцангуй хялбар байсан бөгөөд орчин үед дизайныг тодорхойлоход улам бүр төвөгтэй болж байна. Тухайн үед мэргэжлийн үүднээс дизайныг “хэрэглээний хийгээд гоо зүйн өндөр шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг зохион бүтээх уран сайхны зураг төслийн болон хүний амьдрах орчныг таатай болгоход чиглэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа юм” (Ковешникова, 2009) гэж тодорхойлж байв.

Зураг 1



Герберт Рид дизайныг ямар нэгэн явцуу хүрээнд баригдаагүй урлагийн дээд хэлбэр хэмээн тодорхойлж, дизайны бүтээлүүдийг хийсвэр урлагийн бүтээлд хамааруулж байсан бол Жон Глоаг дизайныг худалдааны талаас нь “хөгжүүлсэн сэтгэмж ба практик ур чадварын зохист нэгдлийн үр дүн” хэмээн дүгнэж, үйлдвэрлэлийн системийн үйлчилгээ гэж тодорхойлж байв. Эшфорд дизайны үйл ажиллагаанд ёс зүй болоод гоо зүйн үндсээс татгалзаж, зөвхөн хэрэглэгчдийн эрэлтийг хангахад чиглүүлэхийг санал болгож, Жио Понти шинэ сайхан зүйлсийг бүтээх боломжийг бүрдүүлэх уран сайхны арга хэмээн үзэж байжээ. Жорж Нельсон дизайныг “соёл иргэншлийн нэн таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн, гэвч уран бүтээлийн дотоод эрх чөлөөг хадгалсан мэргэжил,

уран бүтээлчийн өөрийгөө илэрхийлэх боломжтой олон нийтийн урлагийн шинэ хэлбэр”, Томас Мальдонадо “шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан “цэвэр” дизайныг бүтээхэд чиглэсэн уран бүтээлийн өвөрмөц хэрэгсэл”, Жило Дорфлес, Абрам Моль нар “эрэмбэлэгдсэн мэдээллийг дамжуулах арга, онцгой хэрэгсэл” хэмээн үзэж байжээ. (Михайлов, 2002)

1964 онд Брюгг хотод болсон дизайны боловсролын олон улсын семинараас “Дизайн гэдэг бол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний албан ёсны шинж чанаруудыг тодорхойлох зорилготой уран бүтээлч үйл ажиллагаа юм. Эдгээр чанар нь бүтээгдэхүүний гадаад хэлбэр, бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн ба үйлдвэрлэгчийн зүгээс нэгэн бүхэл болгох бүтцийн болоод үүрэг зориулалтын харилцан холбоог агуулна.” гэсэн тодорхойлолтыг гаргажээ. (Михайлов, 1999) Уран сайхны зураг төсөл, үйлдвэрлэл, инженерийн зохион бүтээлт, шинжлэх ухаан гэх мэт олон төрлийн үйл ажиллагааны нэгдлээс төрсөн дизайныг хүний амьдралын бүхий л орчныг хамарсан биет орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, байгаль, нийгэм, техникийн болон хүмүүнлэгийн ухааны ойлголтууд, инженерийн болон уран сайхны сэтгэлгээг нэгтгэсэн уран сайхны зохион бүтээлтийн цогц шийдэл гэж ойлгож байлаа. (Ковешникова, 2009)

Дизайны мөн чанарт хандах өөр нэг ойлголт гарч байсан нь дизайн бол урлаг биш, урлагт хамааралгүй биет орчныг бүтээн байгуулах төсөл юм гэж үзэх өрөөсгөл үзэл юм. Энэ хандлагыг 1920–иод оны үед дизайн болон шинэ урлагийн холбоог судлаж байсан үйлдвэрлэлийн урлагийн онолч Б.Арватов томъёолжээ. Арватов болон үйлдвэрлэлийн онолыг баримтлагчид дизайныг урлагаас төрсөн хэдий ч урлаг биш, машинт үйлдвэрлэлээр бүтээгдэх, үйлдвэрлэлийн төдийгүй хэрэглээний нөхцлийг тооцоолсон эдлэлийн зохион бүтээлт бөгөөд урлаг нь хүний үйл ажиллагааны хэлбэрээр үйлдвэрлэлд бүрэн шингэн нэгдэх ёстой гэж үзэж байжээ. (Аронов, 1992) Дизайныг урлагийн бус зохион бүтээлт гэж үзэх өөр нэг үзэл болох дизайны томоохон онолчдын

нэг Томас Мальдонадогийн удирдаж байсан Ульмын Дээд Сургуульд боловсруулсан үзэл баримтлалаар “дизайн, урлаг хоёр хүний үйл ажиллагааны зэрэгцэн орших хэлбэр тул дизайн нь урлагийг орлож чадахгүй. Дизайн нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний зохион бүтээлт бөгөөд дизайны түүх бол XX зууны урлагийн гоо зүйн түүх биш, үйлдвэрлэлийн зохион бүтээлтийн түүх юм “ гэж үзжээ. Энэхүү дизайны нэг талыг барьсан өрөөсгөл хандлага 1920-1930-аад оны үеийн эдийн засгийн хямралтай давхацсан Америкийн дизайн зэрэгт тод туссан байдаг. 1929 оны хямрал хүртэл хугацаанд Европын дизайны үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө маш бага байсан тул үүнийг зөвхөн тухайн цаг үеийн Америкийн үзэгдэл гэж болно (Михайлов, 2002).

Бараг бүтэн зууны өмнөх эдгээр үзэл баримтлал нь тухайн цаг үедээ тодорхой хэмжээнд тохирч байсан гэж хэлж болох боловч орчин үеийн дизайнд огт тохирохгүй юм.

Тухайн үеийн Европын дизайны төдийгүй соёлын хамгийн тод үзэгдэл нь “Баухаузын академийн дизайн” байв. Баухауз нь дээд мэргэжлийн хэдэн арван дизайнерыг бэлтгэсэн, Америкийн Нэгдсэн Улсад цагаачилсан багш нар нь дизайны хөгжилд асар ихээр нөлөөлсөн хэдий ч, тухайн цаг үеийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаанд үзүүлсэн шууд нөлөөлөл нь харьцангуй бага байжээ.

Дизайны талаар маш олон тодорхойлолт гарч байсан ч, түүний гол мөн чанарыг тодорхойлсон нэгдсэн дүгнэлт маргаантай хэвээр байна. Учир нь хөгжлийн явцад дизайны шинэ шинэ төрөл бий болж, өргөжин тэлж буйгаас шалтгаалан анх уран барилга, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зэрэг биет зүйл болон түүнийг бүтээх уран сайхны зохион бүтээлтийн ажлын цогцыг илэрхийлж байсан дизайны ойлголт маш эрчимтэйгээр хувьсан өөрчлөгдөж, биет бүтээгдэхүүний хүрээнээс халин, оюун санааны бүтээгдэхүүний өргөн хүрээг агуулсан ойлголт болон хөгжиж байна. Энэхүү биет бус ойлголтууд өнөөгийн дизайны дийлэнх хувийг эзлэх болсноор



өмнөх тодорхойлолтууд таарахгүй болжээ.

Орчин үед дизайны мөн чанар ихээхэн нарийсч, дизайныг урлагийн болон үйлдвэрлэлийн бусад салбар дахь уран бүтээлчийн үйл ажиллагаанаас ялгаж салгахад төвөгтэй болж байна. Оросын томоохон судлаачдын нэг В.Л.Глазычев “О дизайне” номдоо “Дизайн бол материаллаг болон оюунлаг хэрэглээний нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн үнэ цэнийг бий болгодог уран сайхны зохион бүтээлтийн ажлын зохион байгуулалттай хэлбэр юм” гэж тодорхойлсон нь дизайны үйл ажиллагааг бүрэн хамрахаас гадна уран сайхны бусад төрлөөс ялгаж, дизайны материаллаг болон оюунлаг хэрэглээний бүтээгдэхүүний онцлогийг тодорхойлсноороо ач холбогдолтой юм. (Глазычев, 1970)

Өнөөдөр шинэ технологийн хөгжлийг даган юмсын дүрс, хэлбэрийг илэрхийлэх ойлголт байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж буйтай холбоотойгоор дизайны үйл ажиллагаа ихээхэн өөрчлөгдөж байна. График дизайнерууд вэб дизайн, интерактив програм хангамж, хөдөлгөөнт дүрслэл, дуу дүрс хосолсон мультимедиа дизайн, телевиз, кино урлаг гэх мэт олон салбарт ажиллах боломжтой болж, график дизайн болон бусад медиа, бүтээгдэхүүний дизайны ялгаа багасан, хосолсон хэлбэрүүд бий болж, дизайны бодит байдал нарийн төвөгтэй болохын зэрэгцээ нийгэмд үзүүлэх нөлөө нь улам нэмэгдэж буй тул дизайнеруудад энэ бүхнийг зөв тодорхойлох чадвар шаардагдах боллоо.

“Дизайн” хэмээх үгний толь бичиг дахь утга олон салаалахын хэрээр түүний үндсэн судлагдахуун улам бүдгэрч байна. Дизайныг Англи хэлээр тодорхойлбол **“Design is to design a design to produce a design”** гэсэн өгүүлбэр болно хэмээсэн Жон Хескеттийн тодорхойлолт орчин үеийн дизайны энэхүү олон талт байдлыг илэрхийлнэ. (Хэскетт, 2005)


Орчин үед дизайны объект юу ч байж болно. Тээврийн хэрэгсэл, үйлдвэрийн тоног төхөөрөмж, номын болон сурталчилгааны график, хувцасны

элементүүд, тавилга, интерьер, хотын гудамж, барилга байгууламж гэх мэт бидний хүрээлэн буй орчны биет объект, тэдгээрийн цогцоос гадна цахим сүлжээнд эргэлдэж буй эрэмбэлэгдсэн мэдээлэл хүртэл дизайнерын үйл ажиллагааны чиглэл байж болно (Рунге, 2006). Бүх нийтийн дизайн гэдэг ойлголтыг гаргаж ирсэн XX зууны дизайны гүн ухааны хамгийн том төлөөлөгчдийн нэг бөгөөд экодизайны салбарын анхдагчдын нэг гэж тооцогддог Чех гаралтай Америк дизайнер Виктор Папанек (1925-1998) “Бүх хүн дизайнер. Хүн өөрийн бүх үйл ажиллагааг төлөвлөдөг учраас бидний хийж буй бараг бүх зүйл дизайн байдаг. Тавьсан зорилгодоо нийцүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөх нь дизайны мөн чанар юм. Дизайныг онцгойлон ялгаж, бие даасан зүйл болгох гэсэн оролдлого дизайны эсрэг ажилладаг. Туульсын яруу найраг зохиох, ханын зураг зурах, бүтээл хийх, концерт тавих – энэ бүхэн дизайн. Мөн бичгийн ширээгээ эмхлэх, шүд тэгшлэх, алмны бялуу жигнэх, бэйсболын талбай байгуулах, эсвэл хүүхдийг хүмүүжүүлэх хүртэл мөн л дизайн юм. Дизайн гэдэг бол чухал зүй тогтлыг бүтээх ухамсартай болон зөнгөөрөө хийж буй хүчин чармайлт юм” гэж тодорхойлсон байдаг. (Папанек, 2004) 1960-70-аад оны үед түүний гаргасан “Бодит ертөнцөд зориулсан дизайн” ном нь тухайн үеийн функционализмын онол, дэгжин хийц хэлбэрийн санаануудыг доргиосон, архитектур, дизайны ертөнцөд хувьсгал хийсэн номны нэг юм гэж В.Аронов дүгнэжээ. (Аронов, 1992) Энэ ном дизайны сургуулиудын заавал унших номын жагсаалтанд орсон байна. Иймээс дизайны өвөрмөц онцлогийг түүний **объектоор илэрхийлэх боломжгүй** боловч, ерөнхийд нь эдлэлийн, орчны, мэдээллийн болон хийсвэр (виртуаль) гэх мэтээр ангилах боломжтой. Дизайны анхдагч хэлбэр нь уран барилгатай холбож үзвэл орчны дизайн, машинт үйлдвэрлэлтэй холбож үзвэл эдлэлийн дизайн байх боломжтой. Харин мэдээллийн болон хийсвэр объектын дизайн нь XX зууны сүүл үеэс эхэлсэн XXI зууны төрлүүд гэж хэлж болно.

XX зууны дизайны томоохон

онолчдын ажлаас тус тусдаа зорилготой олон дизайн байдаг гэсэн дүгнэлтэд хүрч болох юм. Гэвч бүгдийг нэгтгэн бодож үзвэл, дизайны үндсэн зорилго нь хүний биет орчныг цэгцлэхэд оршино гэсэн ерөнхий дүгнэлт гаргаж болно (Рунге, 2006). Соёлын үндсэн зорилго нь хаосыг эмх цэгцэд оруулахад оршдог гэж үздэг. Гэвч дизайны өвөрмөц шинэ шийдэл нь соёлын энэхүү эмх цэгцийг эвдсэн элементийг оруулснаар хөдөлгөөнтэй болон тогтмол байдлыг тэнцвэржүүлдэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөтэй, урьдчилан харах боломжтой нөхцөл, санамсаргүй байдлын тэнцвэрийг хангадаг. Иймээс цаг үеэ даган байнга өөрчлөгдөн хувирч, олон янзаар илэрч байдаг дизайныг **зорилгоор нь тодорхойлох боломжгүй** гэж хэлж болно.

Зураг 2



Дизайн нь өнгө, хэлбэр, гадаргуугийн талаар уран барилга болон дүрслэх урлаг, суурь болон хавсарга урлагийн бусад төрлийн эртнээс боловсорсон зохиомжийн арга, хэрэгслүүд, шинжлэх ухаан, инженер, зохион бүтээлтийн аргуудыг идэвхтэй ашигладаг. Хэдэн арван жилийн турш дизайны асуудлаар онол, аргазүйн материалууд боловсруулагдан гарч байсан ч дизайн нь зорилгоосоо хамааран бусад салбарын бүтээлч аргуудыг боловсруулан ашигладаг тул **дизайныг өөрийн тогтсон аргаар нь тодорхойлох боломжгүй** юм.

Дизайн, зохион бүтээлтийн аргазүйд эргономикаас гадна тухайн хэрэглэгчдийн нийгэм, соёл, сэтгэл зүйн онцлогийг тооцож үзэх нь дизайны хэрэглээний болон хүмүүнлэг зорилтыг тодорхойлно. Хэрэглэгч нь нас,

хүйс, хөрөнгө чинээ, нийгмийн давхарга, соёл, хүсэл сонирхлоос хамаарахгүйгээр хэн ч байж болно. Хэрэв дизайны бүтээгдэхүүн амьдрах орчныг нь хангахад чиглэгдсэн бол мал, амьтад ч дизайны шууд хэрэглэгч байж болно. Хэрэглэгч нь хэн ч байж болох учир **дизайныг хэрэглэгчээр нь тодорхойлох боломжгүй** юм.

Үүнээс гадна дизайнер хүнд дүрслэх урлаг, инженер техникийн, зохион бүтээлтийн нэгэн адил дүрслэн бодох сэтгэлгээ, системтэй, шинэлэг сэтгэлгээ хөгжсөн байх шаардлагатай. Дизайны бүхий л зохион бүтээлтэд түүний бүтэц, үүрэг, зориулалтаас гадна "гоёсайхан" гэдэг ойлголт салшгүй холбоотой байдаг. Америкийн судлаач Дональд А. Норман дизайны сэтгэл зүйн нөлөөлөл нь хэрэглээнээс илүү чухал хэмээн үзэж, дизайны бүх ойлголт танин мэдэхүйгээс гадна сэтгэл хөдлөлийн үйл явцаар холбоотой гэж үзсэн байна. (Норман, 2006)

Японы дизайны онолч К.Экуан "дизайн баяр баясгаланг авчирч байх ёстой" хэмээн үзэж, дизайн дор хаяж хүний биеийг төдийгүй сэтгэл санаа, соёл, дотоод мөн чанар, түүхийн хувьд эвдэх ёсгүй гэсэн экологийн хандлагыг чухалчилж байв. (Демидов, 2005)

Дизайны үүсэл нь машин, техникийн гоо зүйн ойлголт, ХХ зууны эхэн үеийн уран зургийн хийсвэр урсгалууд болон функционализмын онолтой шууд холбоотой болох нь XIX-XX зууны зааг дээрх уран зураг, дизайны уялдаа холбоо, гол төлөөлөгчдийнх нь намтраас тод харагдаж байна. Ван де Вельд Ван Гогийн шавь уран зураач, Петер Беренс зураач байсан бол, Ле Корбюзье архитектор болохоосоо өмнө А.Озафаны хамт пуризмыг үндэслэсэн, В.Татлин уран зурагаас, Л.Лисицкий номын чимэглэлийн зураачаас тус тус дизайнд шилжсэн зэрэг олон баримтыг дурдаж болно. Дизайны төслүүдтэй ажиллахаасаа өмнө Америкийн дизайны анхдагчдын нэг Белл Геддес, Хенри Дрейфус нар театрын зураач, Реймонд Лоуи загварын сэтгүүлд зураг зурдаг, Макс Билл уран зураг, уран баримал, уран барилга, Жио Понти график, монументаль, тайз чимэглэл, уран барилгач, зураач зэрэг олон мэргэжлийг



эзэмшсэн байна.

Эдгээр бүх ойлголтоос үзэхэд, орчин үеийн дизайны гол шинж нь хүний оюун санаа, сэтгэхүйн бүтээгдэхүүн болохын зэрэгцээ урлаг, уран бүтээлч үйл ажиллагааны хөгжилтэй холбогдож, урлагийн нэгэн шинэ чиглэл байдлаар илэрч байна. Иймээс орчин үед **дизайны урлаг** хэмээх нэршил түгээмэл хэрэглэгдэж байгаа билээ. Дизайн үүссэн цагаасаа хоёрдмол чанартай үзэгдэл бөгөөд орчин үеийн хөгжлийн шинэ шатанд хүрч, арга чанар болох материаллаг ухагдахуунаас илүүтэй, түүний билэг чанар болох оюун санаа, сэтгэлгээний ойлголтод ихээхэн анхаарах болсноор хүний оюун ухаанаас төрж, уран сайхнаар боловсруулсан биетэй болон биегүй бүхий л зүйлийг ойлгож болох асар өргөн ойлголт болсон байна.

## ДҮГНЭЛТ

Орчин үед дэлхий нийтээр хүний сэтгэлгээний хөгжлийг чухалчлан үзэж байна. Хүний чөлөөт сэтгэлгээ нь бага насанд тод илэрч байдаг төрөлх чанар юм. Иймээс олон улсын чиг хандлагаар бага боловсролын хүрээнд хүүхдийн энэхүү баригдмал бус чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхэд анхаарч байгаа бол дунд, ахлах түвшинд бүтээлч сэтгэлгээ буюу креатив (creative) сэтгэлгээг хөгжүүлэхэд анхаарч байна. “Креатив” гэдэг ойлголтыг монголчууд эртнээс “ухааны ур” хэмээх оновчтой үгээр тодорхойлсон байдаг. Чөлөөт сэтгэлгээ, уран сайхны мэдрэмж, зохиомжийн мэдлэг, бүтээлч хандлага зэрэг ойлголт нэгдэн “ухааны ур” төлөвшинө.

Чөлөөт сэтгэлгээг тэтгэх, хөгжүүлэх гол хэрэгсэл нь дүрслэх урлагийн хичээл болно. Харин бүтээлч (creative) сэтгэлгээг хөгжүүлэх гол суурь нь дизайн болж байна.

XX зууны соёлын үзэгдэл болохын хувьд тухайн цаг үедээ уран барилга, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зэрэг биет зүйл болон түүнийг бүтээх уран сайхны зохион бүтээлтийн ажлын цогцыг илэрхийлж, хэрэглээний урлаг хэмээн тодорхойлогдож байсан дизайны ойлголтын мөн чанар XXI зуунд ихээхэн өөрчлөгдөж, биет бүтээгдэхүүний хүрээнээс халин, оюун санааны бүтээгдэхүүний өргөн хүрээг

агуулсан ойлголт болон хөгжиж, энэхүү биет бус ойлголтууд дийлэнх хувийг эзлэн орчин үеийн амьдрах ухааны боловсролын гол чиг хандлагыг тодорхойлох болсноор хөгжлийн тодорхой үе шатуудад гарч байсан өмнөх тодорхойлолтууд таарахгүй болжээ.

Дизайн нь бусад шинжлэх ухаан, урлаг, мэдээлэл харилцааны технологитой нягт уялдан, уламжлалт уран барилгын болон үйлдвэрлэлийн дизайн, хувцасны дизайн, график дизайнаас гадна ландшафт дизайн, хэвлэлийн ба сурталчилгааны дизайн, эко болон тогтвортой хөгжих /sustainable/ дизайн, компьютер болон мультимедиа дизайн гэх мэт орчин үеийн шинэ шинэ төрөл бий болж өргөжин нийгмийн бараг бүхий л салбарыг хамран эрчимтэй хөгжиж байна.

Хоёрдмол мөн чанартай үзэгдэл болох дизайны ойлголтын хөгжил шинэ шатанд хүрч, оюун сэтгэлгээний бүтээгдэхүүн бүрд шингэх болсноор арга чанар болох материаллаг ухагдахуунаас илүүтэй, түүний билэг чанар болох оюун санаа, сэтгэлгээний ойлголтод ихээхэн анхаарах болжээ.

Иймээс дизайны боловсрол XXI зууны иргэдийн мэдлэгийн зайлшгүй эзэмшвэл зохих чухал хэсэг болж, дэлхий нийтээр энэхүү өвөрмөц чиг хандлагатайгаар эрчимтэй хөгжиж буй шинэлэг ойлголтыг сургуулийн өмнөх түвшнээс эхлэн шат дараатайгаар тогтвортой хөгжих насан туршийн боловсролын хүрээнд хөгжүүлж байна.

Монгол орны хувьд, дунд сургуулийн боловсролын хөтөлбөрт дизайны агуулга хангалттай байгаа хэдий ч, бие даан ороогүй, зарим нэгэн хичээлийн хавсарга байдалтайгаар тусгагдсан нь сүүлийн үед дизайны мэргэжилтэн эрэлт ихтэй, уг чиглэлээр бэлтгэдэг их, дээд боловсролын байгууллага олноор бий болж буй өнөөгийн нөхцөлд анхаарвал зохих чухал асуудал үзэх бүрэн үндэстэй юм.

Иймээс Монгол оронд шинээр тавигдаж буй бүх нийтийн дизайны боловсролыг дээшлүүлэх асуудалд анхаарал хандуулах цаг нэгэнт болжээ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Аронов, В.Р. (1992). Теоретические концепции зарубежного дизайна. Москва: ВНИИТЭ.
- Безмоздин, Л.Н. (1990). В мире дизайна. СССР, Ташкент: Изд-во “Фан”.
- Глазычев, В.Л. (1970). О дизайне. Москва: “Искусство”.
- Демидов, Н. Ю. (2005). Теоретическая модель проектирования гармоничной предметной среды средствами индустриального дизайна (Диссертация на соискание ученой степени кандидата искусствоведения). РФ. Екатеринбург.
- Ковешникова, Н.А. (2009). Дизайн: История и теория. Москва: “Омега Л”.
- Михайлов, С., Кулеева Л. (1999). Основы дизайна. Казань: “Новое Знание”.
- Михайлов, С.М. (2002). История дизайна. (Том 1-2). Москва: Союз Дизайнеров России.
- Михайлов, С.М. (2002). История дизайна. (Том 2-2). Москва: Союз Дизайнеров России.
- Норман, Д.А. (2006). Дизайн привычных вещей. :ИД. “Вильямс”.
- Ньюарк, К. (2005) Что такое графический дизайн: ООО “Издательство Астрель”.
- Папанек, В. (2004) Дизайн для реального мира. Москва: Изд. Д.Аронов.
- Паранюкшин, Р.В. (2005) Композиция: теория и практика изобразительного искусства. Ростов н/Д: Феникс.
- Рунге, В.Ф. (2006). История дизайна, науки и техники, Москва: “Архитектура-СЗ”.
- Ткалич, С.К. (2007). История дизайна: эволюция, методология, современные тенденции /учеб. пособие : С. К. Ткалич ISBN 5-94778-136-0.
- Gombrich, E.H. (1998) The Story of Art. USA: Phaidon Press Ltd,
- Heller, S. (2005) The Education of a Graphic Designer. 2-nd Edition. Canada: Allworth Press.
- Heskett, J. (2005). Design: A Very Short Introduction USA: Oxford University Press,
- Masson, P. L., Dorst K., Subrahmanian E. (2013). Design theory: history, state of the art and advancements. *Research in Engineering Design*. 24(2). 97-103.